



**ХУУЛЬ ЗҮЙН  
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ХУУЛЬ БУС  
ХӨРӨНГИЙГ ХУРААН АВАХ, НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГАЛДАХ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/ТҮР БОЛОН БҮР ХУРААН АВСАН, ЦАРЦААСАН  
ХӨРӨНГИЙГ ЭРХЛЭН УДИРДАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ  
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО/**

**2025**

**СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**I сар**



**Судалгааг захиалагч:**

Хууль зүй, дотоод хэргийн яам

**Судалгааг хянасан:**

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,  
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

**Судалгааг удирдсан:**

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,  
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

**Судалгааг гүйцэтгэсэн:**

Г.Болор-Эрдэнэ

Эрдэм шинжилгээний ажилтан



## АГУУЛГА

|  |    |
|--|----|
| I. УДИРТГАЛ .....  | 4  |
| II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО.....                      | 5  |
| 2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох..... | 8  |
| 2.2. Хүний нөөцийг тодорхойлох .....                             | 11 |
| 2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох.....                         | 15 |
| 2.4. Үр дүнг тооцох .....  | 17 |
| 2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.....                | 18 |
| III. ДҮГНЭЛТ.....  | 20 |



## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

|      |                                 |
|------|---------------------------------|
| АТГ  | Авлигатай тэмцэх газар          |
| ПГ   | Прокурорын газар                |
| ТГ   | Тагнуулын газар                 |
| ЦГ   | Цагдаагийн газар                |
| ШШГГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар |



## I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030)” зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсад авлигагүй нийгмийг цогцлоон бүрдүүлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүн нас барсан, сураггүй алга болсон, оргон зайлснаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж, улсын орлого болгох тогтолцоог бий болгоно гэж тус тус заасан.

Иймд шударга ёсыг хангах, нийтийн албан тушаалтны гэмт хэргийг бууруулах, төсвийн хөрөнгө болон нийгмийн ашиг сонирхлыг хамгаалах, хураан авсан хөрөнгийг нийгмийн сайн сайхны төлөө зарцуулах зорилгоор Авлигын эсрэг багц хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн А/41 тоот тушаалаар байгуулан ажиллаж, хуулийн төслийг боловсруулжээ.

Энэхүү судалгаагаар түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын тодорхой үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зардлыг тооцох, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахыг зорилгоо.

Тус хуульд иргэнд үүрэг хүлээлгэх зохицуулалт болон хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул энэхүү зардлын тооцооны судалгааг төрийн байгууллагад үүсэх зохицуулалтын зардлын хүрээнд гүйцэтгэлээ.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов.

## II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.


Аргачлалын 4.4.6 дахь хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг зардлын тооцоонд оруулахгүй. Үүнд:

- 4.1.Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгө (цаашид “хөрөнгө” гэх)-ийн эрхлэн удирдах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, арчлалт, зарцуулалт, зарцуулалтын тайлагналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хөрөнгө эрхлэн удирдах нэгж нь прокурорын хяналт дор эрх бүхий этгээдийн болон шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлнэ.
- 4.2.1.хөрөнгийг хүлээн авах, хүлээн авахын өмнө хөрөнгөд үзлэг хийх, хөрөнгийн төрөл, шинж чанар, бүрдэл, дагалдах зүйлс, холбогдох баримт бичгийн талаар тэмдэглэл үйлдэх;
- 4.2.2.хөрөнгийн үнэлгээг тогтоох;
- 4.2.3.түр хураасан бэлэн мөнгө, төгрөг, гадаад валютыг төрийн өмчийн оролцоотой банкинд хүүтэй хадгалуулах;
- 4.2.4.хөрөнгийг хадгалах, хамгаалах, арчлах, хуульд заасны дагуу түрээслэх ажиллагааг зохион байгуулах;
- 4.2.5.үр ашигтайгаар зах зээлийн ханшаар худалдах арга хэмжээ авах;
- 4.2.6.хураан авсан хөрөнгийг захиран зарцуулснаас олсон орлогыг улсын төсвийнн зориулалтын тусгай дансанд төвлөрүүлэх;
- 4.2.7.хөрөнгө шалгах ажиллагааны хөрөнгөтэй холбогдох бүртгэлийг хөтлөх, үйл ажиллагааны тайланг улирал тутам гаргаж хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, прокурорын байгууллагад тус тус хүргүүлэх;
- 4.4.Хөрөнгө эрхлэн удирдах нэгжийн ажиллах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 5.3.Энэ хуулийн 5.2-т заасан бүртгэлийг дэлгэрэнгүй хөтлөх агуулга, хэлбэр, бүртгэл хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 7.6.Сан болон түүний Ажлын албаны ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.
- 7.2.Сан нь хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллах бөгөөд сангийн ажлын алба хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллана.
- 7.3.Сан нь Удирдах зөвлөлтэй байх бөгөөд уг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн байгууллагын болон олон нийтийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулна.

- 7.4.Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25.5-д заасан хяналтын хороо хяналт тавих бөгөөд уг хорооны бүрэлдэхүүнд олон нийтийн төлөөлөл нь гуравны хоёроос доошгүй байна.

**Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт**

| <p><b>Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт</b></p>   | <p><b>Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт</b></p>  |
|--|--|
| <p>5.5.Прокурор худалдан борлуулах шаардлагагүй, түр хураасан хөрөнгийг хөрөнгө хадгалахад шаардлагатай байр, агуулах, сав, тоног төхөөрөмж, нутаг дэвсгэр, зохих мэргэшсэн багаж хэрэгсэлтэй төрийн байгууллагад хөрөнгийг түр хариуцуулан хадгалуулахаар шилжүүлж болно.</p> <p>5.8.Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг холбогдох төрийн байгууллагад гэрээний үндсэн дээр арчлуулж, хамгаалуулж, хадгалуулна.</p> <p>5.9.Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд гэрээний үндсэн дээр арчлуулж, хамгаалуулж, хадгалуулна.</p> <p>5.12.Түр хураан авсан хөрөнгийн үнэ цэнийг хадгалахад их хэмжээний зардал шаардагдах тохиолдолд энэ хуулийн 5.18-д заасан шийдвэрийг үндэслэн нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж болно.</p> <p>5.15.Прокурор тухайн хөрөнгийг худалдан борлуулж, мөнгөн хэлбэрээр хадгалах хүсэлтийг шүүхэд гаргана.</p> <p>6.4.Хүн, мал амьтан, байгаль орчин, эрүүл ахуй, хорио цээр, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хөрөнгийг Хөрөнгө эрхлэн удирдах нэгжийн даргын шийдвэрээр, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт дор, холбогдох стандарт, дүрэм журмын дагуу устгана.</p> <p>6.7.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгохоор шүүхээс шийдвэрлэсэн тохиолдолд хураагдсан түүх, соёлын үнэт зүйлийг Соёлын өвийг хамгаалах газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p> <p>6.9.Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон бол тухайн хөрөнгийг холбогдох эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлнэ.</p> | <p>5.13.Түр хураан авсан хөрөнгийг 5.12-т заасны дагуу худалдах тохиолдолд Хөрөнгө эрхлэн удирдах нэгжээс үнэлүүлсэн үнэлгээгээр болон түүнээс өндөр үнээр борлуулна.</p> <p>5.14.Түр хураасан хөрөнгийг хоёр удаагийн нээлттэй дуудлага худалдаагаар борлуулж чадаагүй тохиолдолд энэ хуулийн 5.13-т заасан үнэлгээнээс бууруулахгүйгээр шууд гэрээгээр худалдаж болно.</p> <p>6.5.Устгах ажиллагааг дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулан гүйцэтгэх бөгөөд устгах зардлыг Хөрөнгө эрхлэн удирдах нэгж санхүүжүүлнэ.</p> <p>6.6.Улсын орлого болгохоор шүүхээс шийдвэрлэсэн тохиолдолд мөнгөн хөрөнгийг улсын төсөвт зориулалтын тусгай дансанд шилжүүлнэ.</p> |



6.10.Хураан авч улсын орлого болгосон хөрөнгө нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн шүүхийн шийдвэрээр үнэ төлбөргүй олгон ашиглуулж, эсвэл шилжүүлж болно.

10.1.Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтээ дор дурдсан баримтын хамт энэ хуулийн 7.2-т заасан Ажлын албанд хүргүүлнэ:

10.1.1.хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ,тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо мэдээ;

10.1.2.хураан авч улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн нийт үнийн дүн, түүнтэй холбогдох ажиллагааны зардал зэргийг холбогдох байгууллагад тушаасан санхүүгийн баримт.

10.2.Энэ хуулийн 7.2--т заасан Ажлын алба ирүүлсэн албан бичиг, холбогдох тоо мэдээ, баримт материал зэрэгт үндэслэн тухай бүр тушаал гаргаж шийдвэрлэнэ.



## 2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дах аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

### Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

| Гүйцэтгэх байгууллага           | Гүйцэтгэх ажил үүрэг  | Стандарт үйл ажиллагаа   |
|---------------------------------|---|--|
| Прокурорын газар                | 5.5.Прокурор худалдан борлуулах шаардлагагүй, түр хураасан хөрөнгийг хөрөнгө хадгалахад шаардлагатай байр, агуулах, сав, тоног төхөөрөмж, нутаг дэвсгэр, зохих мэргэшсэн багаж хэрэгсэлтэй төрийн байгууллагад хөрөнгийг түр хариуцуулан хадгалуулахаар шилжүүлж болно. | <ul style="list-style-type: none"> <li>- Худалдан борлуулах шаардлагагүй түр хураасан хөрөнгийг хадгалуулах тухай баримт үйлдэх,</li> <li>- Түр хураасан хөрөнгийг бүртгэх</li> <li>- Төрийн байгууллагад хадгалуулахаар хүргүүлэх,</li> </ul>   |
|                                 | 5.15.Прокурор тухайн хөрөнгийг худалдан борлуулж, мөнгөн хэлбэрээр хадгалах хүсэлтийг шүүхэд гаргана.   | <ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгийг худалдах</li> <li>- Шүүхэд хүсэлт бичих</li> <li>- Хүсэлтийг шүүх рүү хүргүүлэх</li> </ul>  |
| Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар | 5.8.Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг холбогдох төрийн байгууллагад гэрээний үндсэн дээр арчлуулж, хамгаалуулж, хадгалуулна.   | <ul style="list-style-type: none"> <li>- Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг төрийн байгууллагад хадгалуулах гэрээг боловсруулах</li> <li>- Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг төрийн байгууллагад хадгалуулах гэрээ байгуулах</li> <li>- Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг хүргүүлэх</li> </ul> |
|                                 | 5.9.Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд гэрээний үндсэн дээр арчлуулж, хамгаалуулж, хадгалуулна  | <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд арчлуулж, хамгаалуулж, хадгалуулах гэрээг боловсруулах</li> <li>- Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд арчлуулж, хамгаалуулж, хадгалуулах гэрээ байгуулах</li> </ul>   |

|  |   |  |
|--|---|--|
|  |   | - Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд арчлуулж, хамгаалуулж, хадгалуулахаар хүргүүлэх   |
|  | 5.12.Түр хураан авсан хөрөнгийн үнэ цэнийг хадгалахад их хэмжээний зардал шаардагдах тохиолдолд энэ хуулийн 5.18-д заасан шийдвэрийг үндэслэн нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж болно.  | <ul style="list-style-type: none"> <li>- Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр, төлбөрийн хэмжээ, хөрөнгийн талаар танилцуулга, түүнийг битүүмжилсэн, барьцаалсан он, сар, өдөр, үнийг танилцуулна.<sup>1</sup></li> <li>- Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь хөрөнгийн үнийг өсгөн дуудах үнийн доод хэмжээг тогтоож, тэмдэглэл үйлдэнэ.</li> <li>- Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг нь дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын гурав хоногийн дотор ялагчийн овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон, өмчлөх эрх үүсэх, өртэй татвар төлөгч эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заасан шийдвэр гаргаж шилжүүлнэ.</li> </ul> |
|  | 6.4.Хүн, мал амьтан, байгаль орчин, эрүүл ахуй, хорио цээр, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх хөрөнгийг Хөрөнгө эрхлэн удирдах нэгжийн даргын шийдвэрээр, холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт дор, холбогдох стандарт, дүрэм журмын дагуу устгана. | <ul style="list-style-type: none"> <li>- Хөрөнгийг устгахдаа мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг үндэслэнэ,</li> <li>- Хөрөнгийг устгахдаа гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлэн, тэмдэглэл үйлдэнэ.</li> <li>- Шаардлага хангасан байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй аюулгүй байдлыг хангасан орчинд явуулна.</li> </ul>  |
|  | 6.7.Түүх, соёлын дурсгалт зүйлийг хураан авч улсын орлого болгохоор шүүхээс шийдвэрлэсэн тохиолдолд хураагдсан түүх, соёлын үнэт зүйлийг Соёлын өвийг хамгаалах газарт үнэ төлбөргүй шилжүүлнэ.   | <ul style="list-style-type: none"> <li>- Түүх, соёлын дурсгалт зүйлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг нь тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ.</li> <li>- Хүлээн авсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлж, соёлын өвийн сан хөмрөгт шилжүүлнэ</li> <li>- Түүх, соёлын дурсгалт зүйлийг хүлээн авсан байгууллага нь</li> </ul>   |

<sup>1</sup> Дуудлага худалдаа зохион байгуулах болон шууд гэрээгээр мөнгөн хэлбэрт шилжүүлэх үйл ажиллагааны нийтлэг журам, Сүүлд үзсэн 2025.01.16, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=210471>

|                               |   |   |
|-------------------------------|---|---|
|                               |   | байгууллагын тайлан балансад бүртгэн авна. <sup>2</sup>   |
|                               | 6.9.Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг хураан авч улсын орлого болгосон бол тухайн хөрөнгийг холбогдох эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагад үнэ төлбөргүй шилжүүлнэ.   | <ul style="list-style-type: none"> <li>- Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ.</li> <li>- Хүлээн авсан шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх</li> <li>- Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагын тайлан балансад бүртгэн авна</li> </ul> |
|                               | 6.10.Хураан авч улсын орлого болгосон хөрөнгө нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд тухайн байгууллагын хүсэлтийг үндэслэн шүүхийн шийдвэрээр үнэ төлбөргүй олгон ашиглуулж, эсвэл шилжүүлж болно   | <ul style="list-style-type: none"> <li>- Төрийн байгууллагын үйл ажиллагаа, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд хөрөнгийг дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ.</li> </ul>  |
| <b>Авлигатай тэмцэх газар</b> | <p>10.1.Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага<sup>3</sup> дэмжлэг авах хүсэлтээ дор дурдсан баримтын хамт энэ хуулийн 7.2-т заасан Ажлын албанд хүргүүлнэ:</p> <p>10.1.1.хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ, тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо мэдээ;</p> <p>10.1.2.хураан авч улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн нийт үнийн дүн, түүнтэй холбогдох ажиллагааны зардал зэргийг холбогдох байгууллагад тушаасан санхүүгийн баримт.</p> <p>10.2.Энэ хуулийн 7.2-т заасан Ажлын алба ирүүлсэн албан бичиг, холбогдох тоо мэдээ, баримт материал зэрэгт үндэслэн тухай бүр тушаал гаргаж шийдвэрлэнэ.</p> | <ul style="list-style-type: none"> <li>- Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтээ боловсруулах</li> <li>- Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх</li> </ul>   |

<sup>2</sup> Шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн, гаалийн байгууллагад хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын сан хөмрөгт шилжүүлэх журам, Сүүлд үзсэн 2025.01.16, Холбоос: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206138&showType=1>

<sup>3</sup> Мөрдөн шалгах эрх бүхий байгууллагийг хуулийн төсөл дээр тодорхой тусгаагүй байгаа тул нийтийн албан тушаалтны хууль бус хөрөнгийг хураах авах, нөхөн төлүүлэх тухай хуулиас үндэслэн мөрдөн шалгах эрх бүхий байгууллагыг тодорхойлсон болно.

|                                |   |   |
|--------------------------------|---|---|
| <p><b>Тагнуулын газар</b></p>  | <p>10.1.Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага<sup>4</sup> дэмжлэг авах хүсэлтээ дор дурдсан баримтын хамт энэ хуулийн 7.2-т заасан Ажлын албанд хүргүүлнэ:<br/> 10.1.1.хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ, тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо мэдээ;<br/> 10.1.2.хураан авч улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн нийт үнийн дүн, түүнтэй холбогдох ажиллагааны зардал зэргийг холбогдох байгууллагад тушаасан санхүүгийн баримт.<br/> 10.2.Энэ хуулийн 7.2-т заасан Ажлын алба ирүүлсэн албан бичиг, холбогдох тоо мэдээ, баримт материал зэрэгт үндэслэн тухай бүр тушаал гаргаж шийдвэрлэнэ.</p> | <ul style="list-style-type: none"> <li>- Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтээ боловсруулах</li> <li>- Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх</li> </ul> |
| <p><b>Цагдаагийн газар</b></p> | <p>10.1.Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага<sup>5</sup> дэмжлэг авах хүсэлтээ дор дурдсан баримтын хамт энэ хуулийн 7.2-т заасан Ажлын албанд хүргүүлнэ:<br/> 10.1.1.хамтран болон дангаар илрүүлсэн гэмт хэргийн тоо мэдээ, тухайн байгууллагын илрүүлсэн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо мэдээ;<br/> 10.1.2.хураан авч улсын төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн нийт үнийн дүн, түүнтэй холбогдох ажиллагааны зардал зэргийг холбогдох байгууллагад тушаасан санхүүгийн баримт.<br/> 10.2.Энэ хуулийн 7.2-т заасан Ажлын алба ирүүлсэн албан бичиг, холбогдох тоо мэдээ, баримт материал зэрэгт үндэслэн тухай бүр тушаал гаргаж шийдвэрлэнэ</p>  | <ul style="list-style-type: none"> <li>- Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтээ боловсруулах</li> <li>- Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх</li> </ul> |

## 2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа** болон **жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

**Зарцуулах хугацааг** тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

**Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор  
үүсэх хүний нөөцийн хэрэгцээ**

| Гүйцэтгэх байгууллага | Стандарт үйл ажиллагаа   | Зарцуулах хугацаа | Тохиолдлын тоо | Хүний нөөцийн хэрэгцээ /мин/ |
|-----------------------|--|-------------------|----------------|------------------------------|
| ПГ                    | 1. Худалдан борлуулах шаардлагагүй түр хураасан хөрөнгийг хадгалуулах тухай баримт үйлдэх,   | 480 <sup>6</sup>  | 1              | 480                          |
|                       | 2. Түр хураасан хөрөнгийг бүртгэх  | 95520             | 1              | 95220                        |
|                       | 3. Төрийн байгууллагад хадгалуулахаар хүргүүлэх  | 300               | 1              | 300                          |
| ШШГГ                  | 1. Хөрөнгийг худалдах  | 43200             | 1              | 43200                        |
|                       | 2. Хөрөнгө худалдах тухай шүүхэд хүсэлт бичих  | 480               | 1              | 480                          |
|                       | 3. Хүсэлтийг шүүх рүү хүргүүлэх  | 300               | 1              | 300                          |
|                       | 1. Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг төрийн байгууллагад хадгалуулах гэрээг боловсруулах        | 6720              | 1              | 6720                         |
|                       | 2. Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг төрийн байгууллагад хадгалуулах гэрээ байгуулах            | 14400             | 1              | 14400                        |
|                       | 3. Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг хүргүүлэх  | 300               | 1              | 300                          |
|                       | 1. Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд арчлуулж, хамгаалуулж, хадгалуулах гэрээг боловсруулах | 6720              | 1              | 6720                         |
|                       | 2. Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд арчлуулж, хамгаалуулж, хадгалуулах гэрээг байгуулах    | 14400             | 1              | 14400                        |
|                       | 3. Гадаад валют, үнэт металл, үнэт болон хагас үнэт чулуу, үнэт эдлэл зэргийг Монголбанкинд  | 300               | 1              | 300                          |

<sup>6</sup> 480 минут буюу ажлын 8 цаг.

|  |      |   |      |
|--|------|---|------|
| арчлуулж, хамгаалуулж, хадгалуулахаар хүргүүлэх  |      |   |      |
| 1. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь дуудлага худалдаа явуулах тухай шийдвэр, төлбөрийн хэмжээ, хөрөнгийн талаар танилцуулга, түүнийг битүүмжилсэн, барьцаалсан он, сар, өдөр, үнийг танилцуулна   | 60   | 1 | 60   |
| 2. Дуудлага худалдаа эрхлэн хөтлөгч нь хөрөнгийн үнийг өсгөн дуудах үнийн доод хэмжээг тогтоож, тэмдэглэл үйлдэнэ.   | 480  | 1 | 480  |
| 3. Дуудлага худалдаа зохион байгуулах ажлын хэсэг нь дуудлага худалдаа явуулснаас хойш ажлын гурав хоногийн дотор ялагчийн овог, нэр, дуудлага худалдаагаар худалдан авсан хөрөнгийн үнийг бүрэн төлсөн болон, өмчлөх эрх үүсэх, өртэй татвар төлөгч эд хөрөнгө чөлөөлөх хугацааг заасан шийдвэр гаргаж шилжүүлнэ. | 6720 | 1 | 6720 |
| 1. Хөрөнгийг устгахдаа мэргэжлийн байгууллагын зөвлөгөөг үндэслэнэ,  | 480  | 1 | 480  |
| 2. Хөрөнгийг устгахдаа гэрэл зураг, дуу дүрсний бичлэгээр бэхжүүлэн, тэмдэглэл үйлдэнэ.  | 480  | 1 | 480  |
| 3. Шаардлага хангасан байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй аюулгүй байдлыг хангасан орчинд явуулна.   | 960  | 1 | 960  |
| 1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг нь тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ.  | 1440 | 1 | 1440 |
| 2. Хүлээн авсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлж, соёлын өвийн сан хөмрөгт шилжүүлнэ   | 1440 | 1 | 1440 |
| 3. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хүлээн авсан байгууллага нь”, байгууллагын тайлан балансад бүртгэн авна   | 960  | 1 | 960  |
| 1. Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг   | 1440 | 1 |      |

|             |   |       |   |                |
|-------------|---|-------|---|----------------|
|             | дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ.   |       |   |                |
|             | 2. Хүлээн авсан шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлэх  | 960   | 1 | 960            |
|             | 3. Шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий хөрөнгийг эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагын тайлан балансад бүртгэн авна  | 480   | 1 | 480            |
|             | 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаа, шинжилгээ судалгаа, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд хөрөнгийг дэлгэрэнгүй жагсаалтыг хүлээлцэж буй ажлын хэсэг тухайн эд зүйлийг нэг бүрчлэн тулгалт хийж, акт үйлдэн хүлээлцэнэ. | 2400  | 1 | 2400           |
| <b>АТГ</b>  | 1. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтийг боловсруулах  | 480   | 1 | 480            |
|             | 2. Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх  | 95520 | 1 | 95520          |
| <b>ТГ</b>   | 1. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтийг боловсруулах  | 480   | 1 | 480            |
|             | 2. Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх  | 95520 | 1 | 95520          |
| <b>ЦГ</b>   | 1. Мөрдөн шалгах эрх бүхий байгууллага дэмжлэг авах хүсэлтийг боловсруулах  | 480   | 1 | 480            |
|             | 2. Хүсэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага руу хүргүүлэх  | 95520 | 1 | 95520          |
| <b>Нийт</b> |   |       |   | <b>487,680</b> |

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр  
 1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/  
 1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

*Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал*

| Нэгж | Хүний нөөцийн хэрэгцээ /мин/ | Жилд шаардагдах ажлын цаг /мин/ | Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/ |
|------|------------------------------|---------------------------------|----------------------------------|
| ПГ   | 96000                        | 96000                           | 1                                |
| ШШГГ | 103680                       | 96000                           | 1.08                             |
| АТГ  | 96000                        | 96000                           | 1                                |
| ТГ   | 96000                        | 96000                           | 1                                |
| ЦГ   | 96000                        | 96000                           | 1                                |

Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд ПГ, АТГ, ТГ, ЦГ тус тус хамгийн багадаа 1 албан хаагч шаардлагатай байна.

Уг хуулийн төсөл нь анхдагч хууль бөгөөд зохицуулалт бүр нь шинээр үүсэж буй харилцааг зохицуулж байна. Хуулийн төслийн 4.1-т “Түр хураасан, хураан авсан, царцаасан хөрөнгө (цаашид “хөрөнгө” гэх)-ийн эрхлэн удирдах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, арчлалт, зарцуулалт, зарцуулалтын тайлагналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын Хөрөнгө эрхлэн удирдах нэгж нь прокурорын хяналт дор эрх бүхий этгээдийн болон шүүхийн шийдвэрийг үндэслэн хэрэгжүүлнэ.” гэж тусгасан ба Хөрөнгө эрхлэн удирдах нэгж нь шинээр бий болох нэгж учир одоогийн шүүхийн шийдвэр гүйцэтгэж буй нэгжүүд болох Хорих ял эдлүүлэх алба, Шийдвэр гүйцэтгэх алба болон Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албийн албан хаагчдын тоог үндэслэн тооцооллоо. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба нь нийт 29 алба хаагчтай ба хөрөнгө эрхлэх нэгжийн албан хаагчийг мөн уг тоогоор авч үзлээ.

**2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох**

Хуулийн төсөлд улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны ангилалд адилтган авч үзэн албан тушаалын жагсаалтаас авч үзэхэд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын



мэргэжилтэн, прокурор, цагдаагийн газрын мөрдөгч, мөрдөгч, байцаагч, мэргэжилтэн, хэсгийн байцаагч, болон гүйцэтгэгч нь “ТЗ-8”<sup>7</sup>-д хамаарч байна. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээг уг хавсралтыг үндэслэж тогтоолоо. ШШГГ-ын мэргэжилтний албан тушаал нь ТТ-8 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ 1,555,000 төгрөг байна.<sup>8</sup> Эндээс жилийн цалин нь 18,666,000 төгрөг, түүнд оногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу жилд 2,332,500 төгрөг байна. Мөн дунджаар хоолны хөнгөлөлтийн дүн 20,000 буюу жилд 4,000,000 төгрөг нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн дүн 1000 буюу жилд 200,000 төгрөг байна. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь ШШГГ, ЦГ, ПГ-ын мэргэжилтэн тус бүр жилд 43,864,500 төгрөг гэж тооцов. Энэ зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны ангилалд адилтган авч үзэн албан тушаалын жагсаалтаас авч үзэхэд ТЕГ-ын ажилтан “ТЗ-10”-д хамаарч байна. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалтны цалингийн хэмжээг уг хавсралтыг үндэслэж тогтоолоо. ШШГГ-ын мэргэжилтний албан тушаал нь ТТ-10 зэрэглэл буюу үндсэн цалингийн хэмжээ 1,411,000 төгрөг байна. Эндээс жилийн цалин нь 16,932,000 төгрөг, түүнд оногдох ажил олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу жилд 2,116,500 төгрөг байна. Мөн дунджаар хоолны хөнгөлөлтийн дүн 20,000 буюу жилд 4,000,000 төгрөг нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн дүн 1000 буюу жилд 200,000 төгрөг байна. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь ТГ мэргэжилтэн нь жилд 23,248,500 төгрөг гэж тооцов. Энэ зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 92 дугаар тогтоолын хавсралтыг үндэслэн Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь 3,293,035<sup>9</sup> төгрөг байна. Эндээс жилийн цалин нь 39,516,420 төгрөг, түүнд оногдох ажил

<sup>7</sup> Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт

<sup>8</sup> Албан тушаалын зэрэглэлээр тогтоосон цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

|       |           |
|-------|-----------|
| ТТ-1  | 2,189,000 |
| ТТ-2  | 2,085,000 |
| ТТ-3  | 1,985,000 |
| ТТ-4  | 1,891,000 |
| ТТ-5  | 1,800,000 |
| ТТ-6  | 1,715,000 |
| ТТ-7  | 1,633,000 |
| ТТ-8  | 1,555,000 |
| ТТ-9  | 1,482,000 |
| ТТ-10 | 1,411,000 |
| ТТ-11 | 1,283,000 |
| ТТ-12 | 1,166,000 |

<sup>9</sup> Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)

олгогчоос төлөх НДШ-ийн хэмжээ нь 12.5 хувь буюу жилд 4,939,552 төгрөг байна. Мөн дунджаар ур чадварын нэмэгдэл 20% буюу 7,309,284 төгрөг, хоолны хөнгөлөлтийн дүн 20,000 буюу жилд 4,000,000 төгрөг нийтийн тээврийн унааны хөнгөлөлтийн дүн 1000 буюу жилд 200,000 төгрөг байна. Иймд төрөөс гарах цалингийн нийт зардал нь АТГ мэргэжилтэн нь жилд 48,655,972 төгрөг гэж тооцов. Энэ зардлыг хүний нөөцийн хэрэгцээнд үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Энэ зардлаа дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

**Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал**

| Нэгж | Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/ | Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал | Хүний нөөцийн зардал |
|------|----------------------------------|--|----------------------|
| ПГ   | 1                                | 43,864,500                                   | 43,864,500           |
| ШШГГ | 29                               | 43,864,500                                   | 1,272,070,500        |
| ТГ   | 1                                | 23,248,500                                   | 23,248,500           |
| АТГ  | 1                                | 48,655,972                                   | 48,655,972           |
| ЦГ   | 1                                | 43,864,500                                   | 43,864,500           |

**2.4. Үр дүнг тооцох**

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

---

|                                     |           |
|-------------------------------------|-----------|
| 2 Авлигатай тэмцэх газрын дэд дарга | 4 041 128 |
| 3 Хэлтсийн дарга                    | 3 984 234 |
| 4 Албаны дарга                      | 3 670 140 |
| 5 Ахлах ажилтан                     | 3 493 365 |
| 6 Ажилтан                           | 3 293 035 |
| 7 Туслах ажилтан                    | 1 880 970 |

**Хүснэгт 7. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал**

| <b>Зардлын төрөл</b>             | <b>Зардлын нэр</b>         | <b>Зардал /төгрөгөөр/</b> |
|----------------------------------|----------------------------|---------------------------|
| Урсгал зардал                    | Бичиг хэргийн зардал       | 121,285                   |
|                                  | Шуудан холбоо              | 167,881                   |
|                                  |                            |                           |
|                                  | Компьютер, тоног төхөөрөмж | 3,351,757                 |
|                                  | Тавилга, эд хогшил         | 53,725                    |
| Зардал                           | Түлш, халаалт              | 199,897                   |
|                                  | Гэрэл, цахилгаан           | 937,251                   |
|                                  | Цэвэр, бохир ус            | 51,947                    |
|                                  | Урсгал засвар              | 53,725                    |
|                                  | Газрын төлбөр              | 1,411                     |
| Элэгдэл, хорогдлын зардал        | Техник, тоног төхөөрөмж    | 356,555                   |
|                                  | Тавилга, эд хогшил         | 100,000                   |
| <b>Нэг албан хаагчид оногдох</b> |                            | <b>5,395,434</b>          |

**Нийт зардлыг тооцох**

**Хүснэгт 8. Нийт зардал**

| <b>Нэгж</b> | <b>Хүний нөөцийн зардал</b> | <b>Материаллаг зардал</b> | <b>Нийт</b>   |
|-------------|-----------------------------|---------------------------|---------------|
| ПГ          | 43,864,500                  | 5,395,434                 | 49,259,934    |
| ШШГГ        | 1,272,070,500               | 5,395,434                 | 1,277,465,934 |
| ТГ          | 23,248,500                  | 5,395,434                 | 28,643,934    |
| АТГ         | 48,655,972                  | 5,395,434                 | 54,051,406    |
| ЦГ          | 43,864,500                  | 5,395,434                 | 49,259,934    |

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд ПГ 49,259,934 төгрөг, ШШГГ 1,277,465,934 төгрөг, ТГ 28,643,934 төгрөг, АТГ 54,051,406 төгрөг, ЦГ 49,259,934 төгрөгийн хүний нөөцийн цалингийн зардалд нийт **1,458,681,142** төгрөг, төрийн байгууллага тус бүр хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 5,756,928 төгрөг, нийт **1,487,465,782** /тэр бум дөрвөн зуун наян долоон сая дөрвөн зуун жаран таван мянга долоон зуун наян хоёр / төгрөгийн зардал үүсэхээр байна.


**2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.**

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

*2.5.1. Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;*

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Хуулийн төслийн зардал үүсч буй зохицуулалт бүрт тохиолдлын тоог тодорхой заагаагүй ба түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах үйл ажиллагаа бүрт явагдах тул тасралтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

*2.5.2. Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;*



Хуулийн төсөлд зааснаар ПГ, ШШГГ, ТГ, АТГ, ЦГ-ын мэргэжилтэнд хамаарал бүхий дээрх зохицуулалтууд нь тогтмол шинжтэй биш тул тухайн үйл ажиллагааны давтамж багасах боломжтой.

*2.5.3. Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;*

Тус хуулийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн зөв хүргэх нь хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж үзэж байна.

*2.5.4. Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;*

Хуулийн төсөлд зааснаар ПГ, ШШГГ, ТГ, АТГ, ЦГ-ын мэргэжилтэнд хамаарал бүхий дээрх зохицуулалтууд бүр мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой.

*2.5.5. Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;*

Түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг холбогдох төрийн байгууллага, Монголбанк, Соёлын өвийг хамгаалах газар, холбогдох эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагад мэдэгдэх зайлшгүй шаардлагатай тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй юм.

### III. ДҮГНЭЛТ

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг. Түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрд учрах зардлыг урьдчилан тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд ПГ 49,259,934 төгрөг, ШШГГ 1,277,465,934 төгрөг, ТГ 28,643,934 төгрөг, АТГ 54,051,406 төгрөг, ЦГ 49,259,934 төгрөгийн хүний нөөцийн цалингийн зардалд нийт **1,458,681,142** төгрөг, төрийн байгууллага тус бүр хүний нөөцийн хангамжийн материаллаг зардалд 5,756,928 төгрөг, нийт **1,487,465,782** /тэр бум дөрвөн зуун наян долоон сая дөрвөн зуун жаран таван мянга долоон зуун наян хоёр/ төгрөгийн зардал үүсэхээр байна.

Хуулийн төсөлд прокурор, ШШГГ, ТЕГ, АТГ, ЦГ-ын мэргэжилтэнд холбогдох үүрэг бүхий заалтуудад тохиолдлын тоог тодорхой заагаагүй ба түр болон бүр хураан авсан, царцаасан хөрөнгийг эрхлэн удирдах үйл ажиллагаа бүрд явагдах тул тасралтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Хуулийн төсөлд зааснаар ПГ, ШШГГ, ТЕГ, АТГ, ЦГ-ын мэргэжилтэнд хамаарал бүхий зохицуулалт нь тогтмол шинжтэй үйл ажиллагаа биш тул тухайн үйл ажиллагааны давтамж багасах боломжтой. Тус хуулийн дагуу мэдээллийн агуулгыг бүрэн зөв хүргэх нь хуулийн үзэл баримтлалд нийцэж байна. Мөн хуулийн төсөлд зааснаар прокурор, ШШГГ, ТГ, АТГ, ЦГ-ын мэргэжилтэнд хамаарах зохицуулалт бүр мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой. Түүнчлэн түүх, соёлын дурсгалт үнэт зүйл, шинжлэх ухааны үнэ цэнэ бүхий зүйл, ховор хөрөнгийг холбогдох төрийн байгууллага, Монголбанк, Соёлын өвийг хамгаалах газар, холбогдох эрдэм шинжилгээний төрийн өмчит байгууллагад мэдэгдэх зайлшгүй шаардлагатай тул мэдээлэл хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжгүй юм.

## ЭХ СУРВАЛЖ

### **Хууль тогтоомж, эрх зүйн акт**

1. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №23;
3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А264, А154 дугаар “Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийх журам” тушаалын хавсралт;
5. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 117 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт “Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ”;
6. Монгол Улсын Их Хурлын 2021 он 04 дүгээр тогтоол “Шүүгчид нэмэгдэл олгох журам батлах тухай”
7. Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 26 дугаар тогтоолын хавсралт “Төрийн тусгай албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”;
8. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ”;

### **Бусад**

1. Авлигатай тэмцэх газар, Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал 2023, (УБ, 2024 он).
2. Цагдаагийн ерөнхий газар, “Цагдаагийн ачаалал”, (УБ, 2021 он) Холбоос: <https://gogo.mn/r/en30m>